

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 5 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 5-р сард Хөдөлмөрийн хэлтэс тбүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 852 болж, 2013 оны мөн үеэс 240 хүнээр буурч, өмнөх сарынхаас 232 хүнээр өсөв.

Ажилгүйчүүдийн 52,35 хувь буюу 446 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 511 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 284 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 37,68 хувь буюу 107 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 5 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 564 ажилгүй иргэний 19,5 хувь нь мэдлэг чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 18,8 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 17,7 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан; 14,7 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 6,0 хувь нь гүйцэтгэж буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 4,6 хувь

нь өөр газраас шилжин ирсэн; 3,5 хувь нь байгууллага татан буугдсан; 2,5 хувь нь орон тооны цомхтголд орсон, 0,9 хувь нь гадаадаас эргэж ирсэн, 0,4 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих; 8,9 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 15,96% нь дээд; 5,87% нь тусгай дунд; 12,44% нь мэргэжлийн анхан шатны; 45,54% нь бүрэн дунд; 15,61% нь бүрэн бус дунд боловсролтой; 17,61% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 5 сард НДШ-ийн

орлого 4918.7 сая ₮ болж төлөвлөгөө 74.48 хувь болж, төлөвлөгөөг бүх сум 10.23-30.24 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 348.2 сая ₮ болж төлөвлөгөө 108.75 хувиар бүх сум давуулан биелүүлжээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 12393.5 сая ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 79.5 хувийг өндөр настны, 10.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.3 хувийг тэжээгчээ алдсаны, 5.5 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 223790 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 36.80% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 26.7%; тэтгэмжийн даатгалын сангийн 96.6%; эрүүл мэндийн даатгалын сангийн 84.0%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 163.9 %; ажилгүйдлийн даатгалын сангийн 144.0 %-ийг тус бүр бүрдүүлжээ

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 5 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 94507 хүнд олгож, 4887.4 сая ₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 1.9 дахин 62769 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 39.1 хувь 1375.7 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 103750 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.70 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 23.40 хувийг халамжийн тэтгэвэр; 9.09 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 5.50 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 1.90 хувийг нийгмийн халамжийн

дэмжлэг тусалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 3.62 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 0.89 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 5 сард 7360 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.8 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 5 сард 558 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 75 хүүхдээр өслөө.


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 5 н сард нялхсын эндэгдэл 4 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 1-ээр буурсан байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй ба өмнөх оны мөн үед харьцуулвал 50 хувиар буюу 1 хүүхдээр буурсан байна.


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 5 дүгээр сарын байдлаар



2014 оны эхний 5 сард нийт гарсан халдварт өвчнөөр 210 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 27.3 хувь буюу 79 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 2.9 дахин, заг хүйтэн 1.4 дахин, тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 24 байгаа бол: Зуунмод 66, Мөнгөнморьт 50, Сүмбэр 49, Дэлгэрхаан 26, Баян-Өнжүүл 25 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар



I.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

агаарын дундаж температур 6-11 градус дулаан буюу Мөнгөнморьт орчмоор 6 градус дулаан буюу сэрүүвтэр,

Өндөрширээт орчмоор 11 градус дулаан

өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 29-34 градус дулаан, Эрдэнэ орчмоор 29 градус, ихэнх нутгаар 30-34 градус, нутгийн баруун өмнөд хэсгээр болон зарим газраар 34 градус хүрч дулаарав.

шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн хүйтэн температур нь -4-13 градус хүйтэн буюу Өндөрширээт орчмоор хамгийн дулаан буюу -4 градус, Эрдэнэ, Мөнгөнморьт орчмоор -13 градус хүйтэн байв.

Сарын нийлбэр тунадас 28,3-91,3 мм байв. Үүнээс хамгийн их нь Мааньт, Эрдэнэд 86,8-91,3 мм, хамгийн бага нь Бүрэнд 28,3 мм тунадас оржээ.

салхины их хурд нийт нутгаар 10-14 м/с, зарим нутгаар 16-18 м/с, түр зуур 20-25 м/с хүрч ширүүсэн зарим газраар аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн хүчтэй салхи, 9-10-нд зарим газраар их цас, бороо орсон байна.

2014 оны 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв.

Төв аймгийн нутгаар. Энэ сард агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 14-19 градус дулаан байх бөгөөд Төв аймгийн зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна. Дундаж нь ихэнх нутгаар 14,5-20,0 градус орчим дулаан байдаг.

Сэрүүвтэр байх үе: Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар шөнөдөө 1-6 градус дулаан, хөрсний гадарга дээр 0-2 градус хүрч сулхан цочир хүйтэрч болзошгүй, өдөртөө 15-20 градус дулаан байна.

Харьцангуй дулаарах үе: Хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар шөнөдөө 9-14 градус, өдөртөө 25-30 градус хүрч халах төлөвтэй.

Бусад хугацаанд: Уулархаг нутгаар шөнөдөө 2-7 градус, өдөртөө 13-18 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 20-25 градус дулаан байх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь: Нийт нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үе болон сүүлчээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар бороо орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Бороо орох үеүдэд салхи зарим газраар түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 5 сард аймгийн хэмжээнд 423 гэмт хэрэг бүртгэгдэж 328 хүн холбогдож төр,

иргэдийн өмчид 1173.6 сая ₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 5 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 39.8 хувь нь хулгай, 26.19 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 11.31 хувь нь бусад хэрэг. 16.6 хувь нь замын осол, 4.7 хувь нь танхай дээрэм, 1.19 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Лүн, Эрдэнэ, сумдад 10000 хүнд 171-81 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (48)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 54 хэргээр өслөө.

Зуунмод суманд 21, эмэгтэй 495 эрэгтэй нийт 516 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 26 хүнээр буурлаа.

Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 54 хэргээр өслөө.


Зуунмод суманд 21, эмэгтэй 495 эрэгтэй нийт 516 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 26 хүнээр буурлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 5 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 1155 гүйцэтгэх хуудсанд нийт 3194.2 сая ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 414 гүйцэтгэх хуудсанд ногдох 424.7 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 741 гүйцэтгэх хуудасны 2769.5 сая ₮-өөс 252 хуудасны 1158.9 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 34.01 хувь, үнийн дүнгээр 41.85 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх

хуудсны биелэлт 6.75 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 20.66 нэгжээр тус тус өслөө.



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад **жигжиг худалдаа, үйлдвэрлэлийг** дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 5 сарын 31-ний байдлаар **107294.3** сая ₮, байгаа нь өмнөх оны эцсээс **16194.5** сая ₮-өөр өслөө.

2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт **59280.8** сая төгрөгийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 5 сарын 31-ний байдлаар 36931.1 сая ₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 5 сарын 31-ны байдлаар 285031 иргэний 10766.5 сая ₮ боллоо.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2014 оны эхний 5 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 4217.1 сая, зарлага 23920.9 сая ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 142.51 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Бууны албан татвар, газрыг төлбөр, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, бусад төлбөр хураамж, төсөвт газрын өөрийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2013 оны мөн үеэс 14.3 хувь буюу 495.3 сая ₮-өөр буурлаа. Аймгийн төсвийн орлогын 83.27 хувийг татварын, 14.98 хувийг татварын бус, 0.75 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2013 оны мөн үеэс татварын орлого 7.38 нэгжээр өсч, татварын бус орлого 7.25 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.02 нэгжээр өслөө.

2013 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 30.4 хувь буюу 168.8 сая ₮-өөр өсч 722.4 сая ₮, авлага 15.0 хувь буюу 16.7 сая ₮-өөр буурч 94.8 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 4000.9 сая ₮ болж, төлөвлөгөө 136.93 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 704.7 сая ₮ болж, төлөвлөгөө 251.57 хувь биелж, бүх сумд 8.5 хувь-10.5 дахин давуулан биелүүллээ. Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 3512.4 сая ₮ болж 131.11 хувь биелж, Жаргалант, Баянжаргалан, Алтанбулаг, Борнуур, Баянхангай, Сүмбэр, Өндөрширээт, Сэргэлэн, Батсүмбэр, Мөнгөнморьт, Цээл, Эрдэнэсант, Эрдэнэ, Баян-Өнжүүл, Лүн сумд 47.10-0.70 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2014 оны 5 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үеболох 2010 оны 12 дугаар сараас 46,26%, өмнөх оны мөн үеэс 13,96%, өмнөх сараас 0,25 хувиар тус тус өсөв.

5 дугаар сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний ногооны дэд бүлэг 4,27%; талх гурил, будааны дэд бүлгийн үнэ 3,30%; саахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны дэд бүлгийн үнэ 1,78%; жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 1,23%-аар тус тус өсч, сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 9,10%; төрөл бүрийн өөх, тосны дэд бүлгийн үнэ 1,19%; мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0,19%; хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0,13%-аар тус тус буурав.

Зураг II.4

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 5 дугаар сарын 0,25 хувийн өсөлтийн 0,17 нэгж


(68,09%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнийн өсөлтөөс; 0,09 нэгж (34,77%) нь согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн; 0,07 нэгж (27,91%) нь бусад бараа, үйлчилгээний бүлгийн; 0,02 нэгж (8,72%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0,01 нэгж (5,89%) нь зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнийн өөрчлөлтөөс тус тус шалтгаалжээ.

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 5-р с	
	пунктээр	хуе
Бүгд	0.25	
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.17	6
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.09	3
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.02	
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	-0.03	-1
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.04	1
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.04	-1
07. ТЭЭВЭР	0.00	
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.09	-3
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.07	2



II. Төл бойжилт

6 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 82.02 хувь 1314.0 мянган хээлтэгч мал төллөж, 1322.8 мянган төл гарсны 99.2 хувь 1312.8 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 7.6 хувь буюу 101.0 мянгаар; бойжиж буй төл 8.7 хувь 114.7 мянгаар тус бүр өслөө.



Гарсан төлийн 0.75 хувь болох 9978 толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 92.2 хувь буюу 9196 төлөөр буурлаа. Гарсан ботгоны 1.08, унаганы 1.15, тугалын 0.89, хурганы 0.53, ишигний 1.02 хувь нь тус бүр хорогдов. Архуст, Сүмбэр, Эрдэнэсант, Батсүмбэр, Баянчандмань сумд гарсан төлийнхөө 3.19-1.82 хувь буюу 3470-235 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 50.38 хувийг (бүгд 5027 төл) эзлэв.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	МЯН.ТОЛ				
	2010	2011	2012	2013	2014
Бүгд	634.7	1045.3	1098.1	1198.1	1312.9
Тэмээ	0.2	0.3	0.4	0.4	0.4
Адуу	20.5	32.5	38.3	46.9	53.4
Үхэр	27.0	40.0	46.3	55.8	64.8
Хонь	352.4	569.1	592.1	657.9	712.2
Ямаа	234.7	403.4	421.1	437.2	482.0

Том малын зүй бус хорогдол


2014 оны 6 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.2 хувь буюу 7636 том мал зүй бусаар хорогдсон нь 2013 оны мөн үеэс 2.3 дахин буюу 17668 толгойгоор буурлаа. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянчандмань, Сүмбэр, Мөнгөнморьт, Батсүмбэр, Архуст сумд оны эхний малынхаа 1.1-0.5 хувь буюу 484-258 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 26.08 хувь (бүгд 1992) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр, аймгийн дүнгээр /толгой/

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	486165	25670	9986	25304	7636
Тэмээ	53	3	1	6	6
Адуу	23209	1247	890	1221	730
Үхэр	23487	1127	992	1399	642
Хонь	211397	8950	4017	10446	3171
Ямаа	228019	14343	4086	12232	3087

Оны эхний тэмээний 0.21; адууны 0.26; үхрийн 0.27; хонины 0.17; ямааны

0.25 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 23.13 хувь нь өвчнөөр, 29.52 хувь нь хээлтэгч мал эзлэв.



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 5 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 4552.86 сая₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 103.8 хувь буюу 2319.06 сая₮-өөр өслөө.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур, Алтанбулаг, Өндөрширээт, сумд 37.21-1.32 (эдгээрсумдынүйлдвэрлэлт90.24) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны

зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мөн.төг
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 V	2014 V	2013 I-V	2014 I-V	Дүнд зэглэх % Percentage share to total		2014% 2013%
					2013 I-V	2014 I-V	
Нийт дүн	439.17	1,026.07	2,233.80	4,552.86	100.0	100.0	203.8%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	35.55	477.64	270.08	2,164.85	12.09%	47.55	801.6%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	327.17	492.99	713.11	1,400.50	31.92	30.76	196.4%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	76.45	55.45	1,250.61	987.51	56.0	21.69	79.0%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 1862.8-49.5 хувь буюу 1894.77-16.7 сая₮-өөр өссөн нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 5 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 21.69, боловсруулах үйлдвэрлэл 30.76, уул уурхайн үйлдвэрлэл 47.55 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний 5 сард 943.9 сая ₮-ийн их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 48.9 хувь буюу 309,5 сая ₮-өөр өсөв.

Барилга угсралт их засварын ажлын 60,61 хувь нь орон сууцны бус барилгад; 39,39 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Энэ нь 2013 эхний 5 сартай харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 0,16 пунктээр буурч, инженерийн барилга байгууламжийн ажил 0,16 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Барилгын салбарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 38 хүнээр, цалингийн сан 24,1 сая ₮-өөр тус тус буурав.

Зураг II.1

Барилгын ажлын гүйцэтгэл,

жил бүрийн 5 дугаар сарын байдлаар,
сая төгрөгөөр



II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 5 сард 116.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 36.8 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад 26.44 хувь буюу 30.7 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 36.0 сая ₮ болж, нийт орлогын 78.61 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 23.22 хувийг албан бичгийн, 14.67 хувийг зорчигчдийн, 62.11 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 5 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр

